

АУДИТЫН ТАЙЛАНГ
БЭЛТГЭСЭН:

Булган аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Д.Анхбаяр

Аудитын менежер
Ж.Энхцоодол

Ахлах аудитор
Г.Намчинсүрэн
Аудитор
П.Мөнхтуяа
А.Сувдаа

2018 оны 8 дугаар сар

Уг тайланг аймаг дахь
Төрийн аудитын
газраас авч үзнэ үү:

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70342495, 70342716
утасаар
факс:70342580
дугаараар харилцана
уу

ХАЯГ:

Булган сум 5-р баг
Нутгийн удирдлагын
ордон
Өрөө № 401 тоот

Товчилсон үгийн тайлбар.....2

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга, зүй, шалгуур
үзүүлэлт.....3-4

**Бүлэг 1. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө
түүний биелэлт**

“Булган АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагааны төлөвлөгөө тухайн
жилийн зорилтод түвшин, бизнесийн болон хөрөнгө
оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж,
төлөвлөгөөний биелэлтийг төлөөлөн удирдах зөвлөл
болон, төрийн өмчийн хорооны бодлого зохицуулалтын
газраар хэлэлцүүлэн үнэлүүлжээ.....4-6

Бүлэг 2. Санхүүжилтийн зарцуулалт оновчтой эсэх

ТУЗ-ын тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин,
хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтоолыг хэтрүүлж
төлөвлөсөн хэмжээнд ажиллаагүй, холбогдох хууль журмыг
бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.....7-18

**Бүлэг 3. Дотоод хяналт болон шилэн дансны тухай
хуулийн хэрэгжилт, биелэлт**

Байгууллагын дотоод хяналт сул, шилэн дансны тухай
хуулийн хэрэгжилт хангалтгүй байна..... 18-19

Дүгнэлт.....20

Зөвлөмж.....21

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АЗЗА	Авто замын засвар арчилгаа
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БАЗ	Бэлтгэл ажиллагааны зардал
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

“Булган АЗЗА” ТӨХК-ий 2016, 2017 онын үйл ажиллагаа, хууль журмын хэрэгжилтэнд нийцлийн аудит хийж дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээллэхэд аудитын зорилт чиглэгдээ.

Аудитын хамрах хүрээ:

“Булган АЗЗА” ТӨХК-ий 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, түүнтэй холбогдох судалгаа, нотлох баримт, бусад тусгай сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэл тус тус хамрагдлаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБООУС 100-100, 4000, 4100 дугаар стандартууд болон, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгаж, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, судалгаа тодруулга авч, хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, баримт, материалд тулгуурлан баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, зарим арга хэмжээнээс түүвэрчлэн шалгах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглагдах хууль, тогтомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн акт, холбогдох бичиг баримтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- + Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- + Төрийн аудитын тухай хууль,
- + Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- + Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- + Холбогдох бусад хууль, эрх зүйн акт, тушаал, шийдвэр

Ерөнхий мэдээлэл:

“Булган АЗЗА” ТӨХК нь төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг төрийн захиргааны төв байгууллагатай хийсэн “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Булган аймгийн хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах үүргийг бүрэн хангаж, ашгийн төлөө ажиллахад оршино гэсэн үндсэн зорилтын хүрээнд үйл

ажиллагаагаа явуулж байна. Тус ТӨХК нь 75 ажиллагсадтайгаар А0904 дугаартай Дашинчилэн-Булган чиглэлийн 121 км урттай хайрган болон ердийн хөрсөн, А-0902 дугаартай Булган-Мөрөн чиглэлийн ,,, км урттай асфальто бетон хучилттай, А-13 дугаартай Хутаг-Өндөр-Тэшиг-Улсын чиглэлийн 136.6 км урттай хайрган болон ердийн хөрсөн, А-27 дугаартай Лүн-Дашинчилэн-Батцэнгэл чиглэлийн 172.76 км асфальто бетон хучилттай замуудын засвар арчлалт, 135м-310 м урттай төмөр бетон болон, бетон 6 ш гүүрний арчлалт, шуурхай ажлын 2 хэсгийг хариуцан үйл ажиллагаа явуулдаг байна.

“Булган АЗЗА” ТӨХК-ий төлөөлөн удирдах зөвлөл нь 9-н гишүүнтэй бөгөөд түүний гурван хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй ажилладаг. Төрийн өмч бодлого зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 312 тогтоолоор ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар

Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө түүний
биелэлт

Бүлэг 1

“Булган АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагааны төлөвлөгөө тухайн жилийн зорилтод түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг төлөөлөн удирдах зөвлөл болон, төрийн өмчийн хорооны бодлого зохицуулалтын газраар хэлэлцүүлэн үнэлүүлжээ.

1.1 “Булган АЗЗА” ТӨХК нь үйл ажиллагааны тухайн жилийн зорилтод түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулан ажиллажээ.

Монгол Улсын Төрийн өмчийн хорооны 2012 оны 06 дугаар арын 14-ний өдрийн 274 тоот тогтоолоор “Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийг 1-18 дугаар хавсралтаар баталжээ. Тус байгууллага нь компанийн дүрмийн 8.9.3-д “компанийн үйл ажиллагааны тухайн жилийн зорилтод түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулан батлах” гэж заасны дагуу 2016, 2017 оны үйл ажиллагааны тухайн жилийн зорилтод түвшин, бизнесийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулж ТУЗ-д танилцуулан хэлэлцүүлсэн байна. Төрийн өмчийн хорооны 2016 оны 12 сарын 27 өдрийн 284 дүгээр тогтоолоор 2017 оны зорилтод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч, худалдан авалтын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгууллаж ажиллахыг гүйцэтгэх захиралд тус тус даалгасан байна.

1.2. “Булган АЗЗА” ТӨХК-ий эдийн засгийн үзүүлэлт үнэн зөв, бодитой дүгнэгдэхгүй байх эрсдэл байна.

“Булган АЗЗА” ТӨХК-ий эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт, шийдвэрийн хэрэгжилтийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн, саналыг тусган Зам тээврийн хөгжлийн яамны үнэлгээ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 90 дүгээр тогтоолоор баталсан журмыг багцалсан үзүүлэлтээр 2016 онд 93.3, 2017 онд 86 оноо авч компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан контракт гэрээний биелэлтийг хангалттай, сайн гэж тус тус үнэлүүлжээ. Тус ТӨХК-ий төлөвлөгөө биелэлтийг хүснэгтээр харуулбал:

“Булган АЗЗА” ТӨХК-ийн эдийн засгийн үзүүлэлт, зорилтод түвшиний төлөвлөгөө гүйцэтгэл

/ Хүснэгт-1 мян.төг/

Үзүүлэлт	2016 он		2017 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	650,150.00	1,004,023.50	1,165,315.00	1,049,427.80
Орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажил	205,500.00	602,219.00	120,000.00	334,892.90
Нийт орлого	855,650.00	1,606,242.50	1,285,315.00	1,384,320.70
Цэвэр борлуулалт	855,650.00	1,606,242.50	1,285,315.00	1,384,320.70
Нийт зардал	854,450.40	1,589,227.30	1,276,852.40	1,379,184.40
Үүнээс удирдлагын зардал	251,343.50	238,192.80	254,788.20	284,213.60
Татварын өмнөх ашиг	1,199.60	17,015.20	8,462.60	5,136.30
Цэвэр ашиг алдагдал	1,079.64	15,313.68	7,616.34	4,622.67
Төсвийн төлбөрийн тооцоо	114,320.00	114,320.00	115,000.00	244,672.40
Орлогын албан татварт	120.00	1,701.50	846.30	513.60
Авлага	46,501.40	193,120.30	50,143.00	238,637.60
Өглөг	620,018.90	792,557.30	600,654.00	1,030,794.50
Богино хугацаат өр	46,501.40	227,346.00	35,442.50	465,583.20
Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноглох зардал	1.00	0.99	1.00	1.00

Ногдол ашиг	215.90	3,064.50	1,163.30	2,297.06
Хөрөнгө оруулалт	52,300.00	52,300.00	130,000.00	139,900.00

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн төлөвлөгөө буюу нийт борлуулалтын орлогыг 2016 он, 2017 онд давуулан биелүүлсэн байгаа боловч, эдийн засгийн үнэлгээ, зорилтод түвшинг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөдөг гэсэн тайлбар өгснийг судлан үзэхэд тооцоо судалгаа, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэдэггүй байна. Тухайлбал: Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гүйцэтгэл буюу нийт орлогыг 2016 оны төлөвлөгөөг 2015 оны гүйцэтгэлээс 56.9 хувиар бууруулж, 2017 оны төлөвлөгөөг 2016 оны гүйцэтгэлээс 20 хувиар бууруулж төлөвлөн ТУЗ-өөр хэлэлцүүлэн Төрийн өмчийн хороогоор батлуулсан. Мөн борлуулалтын орлогыг бүрэн тооцоогүй, гүйцэтгэсэн ажлын дутуу санхүүжилтыг тайлант онд бүртгэхгүй дараа онд шилжүүлэн орлогоор хүлээн зөвшөөрдөг байна. Тухайлбал: 2016 онд бусад борлуулалтын орлого 5232.5 мянган төгрөгийг борлуулалтын орлого дансанд бүртгээгүй, 2015 оны Орхон аймагт гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл санхүүжилт 57045.6, техник түрээсийн төлбөр 35790.8 мянган төгрөгийг тайлант онд бүртгээгүй, 2017 онд Орхон аймагт гүйцэтгэсэн ажлын 2016 оны үлдэгдэл санхүүжилт 20282.6 мянган төгрөгийг тайлант онд бүртгэхгүй он дамжуулан дараа онд борлуулалтын орлогоор бүртгэж эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшингийн гүйцэтгэлийг гаргаж дүгнүүлсэн, байгаа нь ТӨХК-ий эдийн засгийн үзүүлэлт үнэн зөв бодитой дүгнэгдэхгүй байх эрсдэл байгааг илэрхийлж байна.

Иймд тус ТӨХК нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшингийн төлөвлөлтийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, нь дээд байгууллагаас гаргасан НББББ-т нийцүүлэн өөрийн байгууллагын бодлогын баримт бичгийг боловсруулан дагаж мөрдөх, шаардлагатай байна.

2016 онд Гамшигаас хамгаалах сангаас 15.0 сая, Авто замын сангаас 22.0 сая санхүүжилт, 2017 онд Хишиг-Өндөр сумын 2 км хайрган хучилттай авто замын ажлыг хийж 18181.8 /НӨАТ-гүй/ мянган төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажлыг хүлээлгэн өгсөн боловч тухайн ажлуудын гүйцэтгэлийг гаргаагүй, ямар норм нормативаар гүйцэтгэсэн нь тодорхой бус, тавьсан хяналт, хүлээлгэж өгсөн акт байхгүй, тухайн ажил хийгдсэн эсэх, ажлын чанар ямар байгааг тодорхойлох боломжгүй байгаа нь зардлуудыг гарсан тухай бүрд нь замын чиглэл тус бүрд нь бүртгэдэггүй нягтлан бодогч бөөн дүнгээр нь хааж бичдэгээс орон нутгийн сангуудаас санхүүжилтээр хийгдсэн ажлыг хичнээн төгрөгийн ашиг алдагдалтай ажилласныг тооцох боломжгүй байгаа нь замын инженер, нягтлан бодогч, удирдлагын ажлын хариуцлага, дотоод хяналт муу байгаатай шууд холбоотой байна.

Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар

Санхүүжилтийн зарцуулалт оновчтой эсэх

Бүлэг 2

ТУЗ-ийн тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтоолыг хэтрүүлж төлөвлөсөн хэмжээнд ажиллаагүй, холбогдох хууль журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.1 ТУЗ-ийн тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтоолыг хэтрүүлж төлөвлөсөн хэмжээнд ажиллаагүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Булган АЗЗА” ТӨХК-ий эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2016 онд нийт орлогыг 855650.0, нийт зардлыг 854450.5, 2017 онд нийт орлогыг 1285315.0, нийт зардлыг 1278852.4 мянган төгрөгөөр тус тус баталж гүйцэтгэлээр 2016 онд орлого 1606200.0, зардал 1589227.2 мянган төгрөг буюу орлогыг 87.7 хувиар давуулан биелүүлсэнтэй холбогдон зардал 86.0 хувиар нэмэгдсэн, 2017 онд орлого 1384320.6, зардал 1379189.3 мянган төгрөг буюу орлогыг 7.7 хувиар давуулан биелүүлсэнтэй холбоотойгоор зардал 8.0 хувиар өссөн байна. Тус компанийн төлөвлөгөө, түүний биелэлтийн дэлгэрэнгүйг дараах хүснэгтээр харуулвал:

“Булган АЗЗА” ТӨХК-ий 2016, 2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт-2 /мян.төг/

Үзүүлэлт	2016 он			2017 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Нийт орлого	855,650.0	1,606,242.5	187.7%	1,285,315.0	1,384,320.7	107.7%
Улсын чанартай зам, засвар арчлалтын ажил	650,150.0	1,004,023.5	154.4%	1,165,315.00	1,049,427.8	90.1%
Орон нутгийн чанартай зам, засвар арчлалтын ажил	205,500.0	602,219.0	293.1%	120,000.00	334,892.9	279.1%
Материалын зардлын дүн	305,230.4	804,733.9	263.6%	545,135.4	631,465.1	115.8%
Түүхий эд материалын зардал	130,000.0	248,260.0	191.0%	235,992.8	271,393.9	115.0%
Шатахууны зардал	68,528.6	169,106.5	246.8%	146,140.8	153,613.9	105.1%
Сэлбэг хэрэгслийн зардал	44,300.0	89,785.1	202.7%	60,261.4	63,132.5	104.8%
Тоног төхөөрөмж	1,120.0	2,129.5	190.1%	2,640.0	2,800.0	106.1%
Дулааны зардал	6,400.0	6,400.0	100.0%	6,400.0	136.5	2.1%
Цахилгааны зардал	5,831.7	4,393.0	75.3%	5,831.7	2,900.2	49.7%

Тээвэр бэлтгэл ажиллагаа	1,200.0	21,129.9	1760.8 %	1,200.0	5,367.6	447.3%
Хөдөлмөр хамгаалал	3,040.0	3,040.0	100.0%	9,854.0	8,525.7	86.5%
Томилолт	2,757.4	6,631.3	240.5%	5,685.4	2,556.0	45.0%
Хээрийн нэмэгдэл	26,182.7	40,963.8	156.5%	35,208.0	47,365.4	134.5%
Бичиг хэрэг	1,500.0	1,500.0	100.0%	1,500.0	1,471.0	98.1%
Техник түрээс	-	73,250.0		10,360.0	17,190.8	165.9%
Газар, байгалийн нөөц ашигласны төлбөр	1,500.0	4,712.6	314.2%	5,000.0	19,615.3	392.3%
Өндөр настны зардал	2,000.0	2,000.0	100.0%			
Түлээ нүүрсний хөнгөлөлт	3,370.0	3,370.0	100.0%	3,370.0	-	0.0%
Бусад зардал	-	44,485.7			19,649.5	
Татвар хураамж, даатгалын зардал	7,500.0	22,602.0	301.4%	15,691.3	15,746.8	100.4%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	-	60,974.5				
Материаллаг бус зардлын дүн	297,876.5	546,300.6	183.4%	476,928.8	463,505.7	97.2%
Үндсэн хөрөнгийн элэгдэл	171,340.6	201,234.1	117.4%	171,340.6	182,632.6	106.6%
Үндсэн ба нэмэгдэл цалин	111,978.7	261,522.9	233.5%	270,432.0	248,571.5	91.9%
НДШ	14,557.2	34,182.2	234.8%	35,156.2	32,301.6	91.9%
Зээлийн хүүгийн зардал	-	49,361.4				
Удирдлагын зардлын дүн	251,343.5	238,192.8	94.8%	254,788.2	284,213.6	111.5%
Удирдлагын зардал	251,343.5	238,192.8	94.8%	254,788.2	284,213.6	111.5%
Нийт зардал	854,450.4	1,589,227.3	186.0%	1,276,852.4	1,379,184.4	108.0%
<i>Татвар төлөхийн өмнөх ашиг</i>	1,199.6	17,015.2	1418.4 %	8,462.6	5,136.3	60.7%
<i>Орлогын албан татвар</i>	120.0	1,701.5	1418.4 %	846.3	513.6	60.7%
<i>Цэвэр ашиг /алдагдал/</i>	1,079.6	15,313.7	1418.4 %	7,616.3	4,622.7	60.7%
<i>Нийт авлага</i>	46,501.4	193,120.3	415.3%	50,143.0	238,637.6	475.9%
<i>Нийт өглөг</i>	620,018.9	792,557.3	127.8%	600,654.0	1,030,794.5	171.6%
<i>Хөрөнгө оруулалт, их засвар</i>	52,300.0	52,300.0	100.0%	130,000.0	139,900.0	107.6%
Нийт ажиллагсдын тоо	71	68	95.8%	71	71	100.0%

Дээрхи хүснэгтээс харахад 2016 онд батлагдсан төлөвлөгөөний дагуу зам, засвар арчлалтын ажлыг хийж гүйцэтгээгүй бөгөөд нийт батлагдсан 19 нэр төрлийн зардлын цахилгааны зардал болон удирдлагын зардлыг хэмнэж, дулаан хөдөлмөр

хамгаалал, бичиг хэрэг, өндөр настан, түлээ нүүрсний хөнгөлөлтийн зардлыг төлөвлөсний дагуу зарцуулсан бол үлдсэн зардлуудыг 56-1658.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс гадна төлөвлөгөөнд тусгагдаагүй техник түрээс, бусад зардал, бусдаар гүйцэтгүүлэх ажил, зээлийн хүүгийн зардал бүхий 4 нэр төрлийн зардалд нийт 228071.6 мянган төгрөгийг зарцуулсан, авлагыг 315.3, өглөгийн 27.8 хувиар хэтрүүлсэн, 2017 онд удирдлагын зардлыг 29425.4, үйлдвэрлэлийн зардлыг 70911.5, хөрөнгө оруулалтын худалдан авалтыг 9900.0 мянган төгрөгөөр зардлыг тус тус хэтрүүлсэн байгаа нь ТУЗ-ын тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тогтоолыг мөрдөж ажиллаагүй, компаний үйл ажиллагаанд зарцуулах зардлыг оновчтой тусгаж төлөвлөөгүй, баталсан зардлын дагуу хөрөнгө оруулалтын худалдан авалт хийгдээгүй, авлага, өглөгийг төлөвлөсөн хэмжээнд тогтоож ажиллаагүй, авлага, өглөг болох хөрөнгийг жилийн эцэст тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчил илэрлээ.

Цаашид эдийн засгийн үзүүлэлт болон зорилтот түвшингийн төлөвлөгөөг боловсруулахдаа боломжит эрсдлийг харгалзан санхүү менежментийг нарийн тооцож төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулж, зарцуулалт хийдэг байхад анхаарч ажиллах шаардлагатайг илэрхийлж байна.

Үүнээс үзэхэд төлөвлөгөөг боловсруулж батлуулахдаа боломжит эрсдлийг харгалзан санхүү менежментийг нарийн тооцож төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулж, зарцуулалт хийдэг байхад анхаарч ажиллах шаардлагатайг илэрхийлж байна.

2.2. Санхүүжилтыг зарцуулж ажил гүйлгээ хийхдээ анхан шатны баримтын бүрдэлтгүй, бүрдэл дутуу ажил гүйлгээ хийсэн, зээл авахдаа гэрээний үндсэн дээр хийгээгүй, холбогдох хууль журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус ТӨХК нь 2016 онд 37017.1 мянган төгрөгийн дансны эхний үлдэгдэл байсан бөгөөд тайлант онд кассаар 221037.3, ХААН банкны харилцах дансаар 802738.2, ХАС банкны харилцах дансаар 1869294.0 мянган төгрөгийн зарцуулалт хийж 225483.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 2017 онд ХААН, ХАС банкны дансны хуулгаар улсын чанартай авто зам арчлалтаас 1208102.2, орон нутгийн авто замын сангаас 293855.9, НДС-гаас 2305.5, ХАС банкнаас авсан шугман зээлээс 227999.0, ажлын хөлснөөс 39000.0, баталгаат барьцаанаас 24019.3, хүүгийн орлогоос 1468.8, бусад орлогоос 83902.4 буюу нийт 1880653.2 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1566466.3 мянган төгрөгийг зарцуулж ХААН банкны 5270197342 тоот дансанд 2870.4, ХАС банкны 5000204038 тоот дансанд 311316.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэйгээр тус тус тайлагнажээ.

2016 оны зардлын зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд кассаар зарцуулалтыг авч үзвэл дараах байдалтай байна.

2016 оны кассын зарцуулалт

Хүснэгт-3 /мян.төг/

№	Үзүүлэлт	Үндсэн касс		Дашинчилэн касс		Нийт	Нийт дүнд эзлэх хувь
		Мөнгөн дүн	Хувийн жин	Мөнгөн дүн	Хувийн жин		
1	Цалин, цалингийн урьдчилгаа	15353.4	7.31%	487	4.46%	15840.4	7.17%
2	Бараа материал сэлбэг	72146.3	34.34%	4389.9	40.21%	76536.2	34.63%
3	Бараа материалын урьдчилгаа	38989	18.56%	0	0.00%	38989	17.64%
4	Хоол, хүнс /хээрийн нэмэгдэл/	17400.3	8.28%	827.6	7.58%	18227.9	8.25%
5	Шатахуун	12359.3	5.88%	1453.8	13.32%	13813.1	6.25%
6	Түрээс	6000	2.86%	50	0.46%	6050	2.74%
7	Томилолт	4356	2.06%	0	0.00%	4356	1.96%
8	Ажлын хөлс	3763.3	1.79%	1204	11.03%	4967.3	2.25%
9	Бараа буулгалт, ачаа тээвэрлэлт	1753.2	0.83%	0	0.00%	1753.2	0.79%
10	Баяр ёслол, шагнал, аялал	11780.4	5.61%	0	0.00%	11780.4	5.33%
11	Бусад	23919	11.40%	2503.8	22.94%	26422.8	11.97%
12	Дашинчилэн кассанд	2301	1.10%		0.00%	2301	1.04%
Нийт дүн		210121.2	100%	10916.1	100%	221037.3	100%

Хүснэгтээс харахад кассаар хийгдсэн гүйлгээний 52.9 хувийг бараа материал, сэлбэг авахад зарцуулдаг байна. Гэвч бараа материал, сэлбэг авахдаа ямар нэр төрлийн, хэдэн тооны материал авах нь тодорхойгүйгээр урьдчилгаа олгодог байна. Тухайлбал : Эрээн хотоос бараа материал, сэлбэг бэлтгэх зорилгоор 2016 оны 04 дүгээр сарын сүүл 05 дугаар сарын эхээр материалын урьдчилгаанд 20363.0 мянган төгрөг авч явжээ. Бараа материал, сэлбэг 15713.0, буудал хоолонд 1397.2, тээвэрлэлтэнд 3260.7 мянган төгрөгийг зарцуулснаар тайлагнасанг баримтаар тулган үзэхэд материал худалдан авсан зарлагын баримт нэгэн ижил, материалыг орлогоор бүртгэж авсанг шалгаж үзэхэд 3000 юань бүхий 923.9 мянган төгрөгийн сэлбэгийг тайлант хугацаанд бүртгэлгүй 07 дугаар сарын 15-нд орлогоор авчээ.

Тайланд 2016 онд кассаас нийт 4356.0 мянган төгрөгийн томилолт олгосноос өмнөх оны өглөгөөр бүртгээгүй 7 ажилтны 995.0, тайланд оны 3361.0 мянган төгрөгийг олгожээ. Тайлант онд олгосон томилолтоос 1300.0 мянган төгрөгийн урьдчилгаа олгож үүний 150.0 мянган төгрөгийг холбогдох ажилтнаас суутгасан, 200.0 мянган төгрөгийн томилолтоор материал бэлтгэсэн бол томилолтын хуудасгүй

950.0 мянган төгрөгийг тооцоо нийлж хаагаагүй зөрчилд, томилолтын хугацаанд байгууллагын ажилчид албан ажлаар томилогдон ажил үүрэг гүйцэтгэж байх хугацаанд тухайн ажилчны хоолны мөнгийг давхардуулан нийт 255.0 мянган төгрөгийг олгосон зөрчилд тус тус хугацаатай төлбөрийн акт тогтоолоо.

2016 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зээлийг тусгаж өгөөгүй ч улсын чанартай зам засвар, арчлалтын ажлын санхүүжилт хугацаандаа ордоггүй, орон нутгийн тендерээр хийгдсэн ажлын санхүүжилт ажил гүйцэтгэж дууссаны дараа олгогддог зэргээс үүдэн компани хэвийн үйл ажиллагаагаа явуулахтай холбоотойгоор ажиллагсадын цалин хөлсийг олгох зорилгоор банк болон хувь хүнээс тодорхой хэмжээний зээлийг авсан байна. Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийг гэрээний үндсэн дээр хийсэн бол хувь хүнээс 71370.0 мянган төгрөгийг бэлнээр зээлдэн тайлант онд бүрэн барагдуулжээ.

Хувь хүнээс авсан зээлийн жагсаалт

Хүснэгт 4 /мян.төг/

№	Орлого огноо	Зээл олгогч	Зээлийн дүн	Төлөлт
1	2016.05.27	Д.Баатарсүрэн	15,000.00	15,000.00
2	2016.06.08	Т.Болдбаатар	4,000.00	4,000.00
3	2016.08.12	Д.Амгалан	16,000.00	16,000.00
4	2016.08.29	Б.Батсайхан	7,000.00	7,000.00
5	2016.09.21	Д.Баатарсүрэн	10,000.00	10,000.00
6	2016.10.03	Батсайхан	1,000.00	1,000.00
7	2016.11.14	Шунхлай петролиум ХХК	1,000.00	1,000.00
8	2016.11.14	Д.Баатарсүрэн	3,500.00	3,500.00
9	2016.12.02	Батсайхан	1,000.00	1,000.00
10	2016.12.19	Амгалан	12,870.00	12,870.00
Нийт дүн			71,370.00	71,370.00

Хэдийгээр зээлийг бүрэн барагдуулсан ч уг зээлийг ямар нэгэн гэрээг үндэслэж хийгээгүй байна. Иймээс уг зээлийг хэр хугацаанд, хэдэн хувийн хүүгийн түвшинтэй эсэхийг тодорхойлох боломжгүй байна. Мөн нотлох баримтгүйгээр бэлэн мөнгийг эргэлтэнд оруулсан нь ирээдүйд үүсэх эрсдлийг агуулж байна.

Мөн 180980.9 мянган төгрөгийн шатахуун усаар болон талоноор авсан бөгөөд талоноор 3644.5 мянган төгрөгийн аккумулятор авч, 480.0 мянган төгрөгийг хувь хүнд “Сэцэд” ХХК-д 3000.0 мянган төгрөгийн шатахууныг ажлын хөлсөнд тус тус өгч, ажиллагсадын цалингаас 1058.0 мянган төгрөгийг суутган, жолооч нараас 989.1 мянган төгрөгийн авлага нэмж үүсгэн нийт 172125.7 мянган төгрөгийн шатахууныг үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулжээ. Зарцуулалтыг анхан шатны баримттай тулган үзэхэд зөрүү үүсээгүй ч зарим жолоочийн замын хуудас тухай бүрдээ хөтлөгдөөгүй

сарын эцэст тооцоо нийлдэггүй зөрчил илэрлээ. “Булган АЗЗА” ТӨХК-нд 2018 оны 07 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд байгууллагад ажиллахад жолоочийн замын хуудсыг хөтөлдөггүй, тооцоо нийлээгүй байж дараагийн ажлыг гүйцэтгэдэг, авсан шатахуундаа тааруулан бичилт хийдэг нь тодорхой байлаа. Мөн шатахуун олгохдоо даргын цохолтгүй, хүлээж авсан, олгосон хүний гарын үсэггүй 6800.4, материал олгохдоо хүлээж авсан хүний гарын үсэггүй 43077.1 нийт 49877.5 мянган төгрөгийн зарцуулалт хийсэнд хугацаатай албан шаардлага өглөө.

“Булган АЗЗА” ТӨХК нь тайлант онд хувь хүн иргэнээс бараа үйлчилгээ худалдан авахдаа ХХОАТ-ыг тооцож суутгаагүй, суутгасан ч суутгалыг өглөгөөр тусгаагүй зөрчилд 8191.0 мянган төгрөгийн хугацаатай төлбөрийн акт тогтоолоо.

Дээрх өндөр дүнтэй худалдан авалтыг хийхдээ харьцуулалтын арга хэрэглээгүй, шууд худалдан авалт хийсэн, жишиг баримт бичгийг үндэслэл болгоогүй зэрэг нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.4, 19.1, 48.5, 49 дэх заалтыг зөрчсөн байна.

2017 оны зардлын зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд нэхэмжлэх зарлагын анхан шатны баримтгүй, бараа материалыг хүлээж аваагүйгээр материалын үнэ шилжүүлж авлагаар тусган авлагаа барагдуулаагүй одоог хүртэл материалаа хүлээж аваагүй, цалингийн урьдчилгаагаар бэлэн мөнгө гаргачихаад материал худалдан авсан, тушаал шийдвэргүй, зардлыг төлөвлөөгүй, нэхэмжлэх зарлагын баримт дутуу бэлэн мөнгөөр гүйлгээ хийгдэж зарцуулсан, туршлага судлах зардлыг зориулалт бусаар үйл ажиллагаандаа зарцуулсан, материалын үнэ илүү шилжүүлээд авлагаар тусгаагүй, худалдах, худалдан авах гэрээ хийгдээгүй, бараа тээвэрлэх гэрээ байгуулаагүй шууд зардал зарцуулсан зэрэг зөрчлүүд илэрч байна. Тухайлбал: Цалингийн урьдчилгаа гэж 2017 оны 02 дугаар сард 2000.0 мянган төгрөг бэлнээр гаргасан боловч материал авсан утгыг андуурч бичсэн гэж тайлбарлан сэлбэг материалыг 2017 оны 11 дүгээр сард бүртгэн авсан, удирлагын хоолны зардалд 1271.9 мянган төгрөг зарцуулсан нь тодорхой бус, ажлын удирдамж шийдвэргүй хоолонд зарцуулсан, 450.0 мянган төгрөгөөр гар утас худалдан авсан нь байгууллагын даргын тушаал шийдвэргүй, АНУ-ын уулзалтанд оролцох ажилтны зардалд 5000.0 мянган төгрөг зарцуулахаар бэлнээр гаргасан боловч Дархан-Уул аймгийн зам арчлалын зардалд зарцуулсан, харилцах дансаар гүйлгээ хийхдээ нэхэмжлэх зарлагын баримтгүй, анхан шатны баримт дутуу, бэлнээр энэ онд нийт 174230.9 мянган төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээ хийгдсэн, материалын үнийг 419.5 мянган төгрөгөөр илүү шилжүүлж авлагаар бүртгээгүй, иргэн О.Болдбаатараас 4030.0 мянган төгрөгийн хонь худалдан авч ХХОАТ болох 403.0, иргэн Сайнбуянд зээлийн хүү гэж 1000.0 мянган төгрөгнөөс ХХОАТ суутгаагүй 100.0 мянган төгрөг зэрэг зөрчлүүд илэрсэнээс авлага, өглөгийн тайланд тусгаагүй 419.5, ХХОАТ суутган тооцоогүй 503.0, нийт 922.5 мянган төгрөгийн зөрчлөөс аудитын явцад 519.5 мянган төгрөгийг төлбөрийг барагдуулж 403.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Дээрхи зөрчлүүд нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.17.4-д “ их хэмжээний болон ашиг сохирхолын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих дүгнэлт гаргах”,

байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичгийн мөнгөн хөрөнгийн маягтыг нөхөх зааврын “Бэлэн мөнгөний гүйлгээ, түүний хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор бэлэн мөнгөний орлого, зарлагын баримтыг хөтлөнө. Компаний гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарын гарын үсэг бүхий мөнгө олгохыг хүссэн баримтыг үндэслэн кассын нярав мөнгөн зарлагын гүйлгээний баримтыг бүрдүүлж гүйлгээ хийх бөгөөд шаардлагатай, баримтуудыг бүрэн гүйцэд эсэхийг магадласны дараа мөнгийг олгоно”, Төсвийн тухай хуулийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай уридах, гүйцэтгэлийг хангах”, ХХОАТ-ын тухай хуулийн 23.1 “энэ хуулийн 17-19 дүгээр зүйл 20.1.2-201.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна”, 2016 онд хүчин төгөлдөр хэрэгжиж байсан нь НББ-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх”, 4.1.6 дахь “тасралтгүй байх” зарчмуудыг, 5.1 дэх “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 5.1.4. “үнэн зөв байх 7.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 7.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, 7.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 7.6 дахь “Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 7.7 дахь “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, мөн шинэчилэн найруулсан НББ-ийн тухай хуулийн 13.6. “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 18.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” 20.2.5. “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай бүрэн нийцэхгүй байна.

Иймд цаашид байгууллагын дотоод журам, НББ-ийн бодлогын бичиг баримтыг мөрдөх, бэлэн мөнгөний тайланг хянаж гүйцэтгэлийн тайланг баталгаажуулах, холбогдох хууль журамыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

2.4 Булган АЗЗА ТӨХК нь 2016 онд авлагыг 371703.9, өглөгийг 311576.6 мянган төгрөгөөр бууруулсан ч, 2017 онд авлагыг 51881.5, өглөгийг 238237.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Өглөг, авлагын үлдэгдлийг өмнөх онтой харьцуулсан хүснэгт

/мян.төг/

Үзүүлэлт	2015	2016	2017	2016 оныг өмнөх онтой харьцуулвал		2017 оныг өмнөх онтой харьцуулвал	
				Мөнгөн дүн	Хувь	Мөнгөн дүн	Хувь
Дансны авлага	558,076.4	184,647.9	227,757.3	(373,428.50)	-66.9%	43,109.40	23.3%
Бусад авлага	6,747.7	8,472.3	10,880.3	1,724.60	25.6%	2,408.00	28.4%
Авлагын дүн	564,824.1	193,120.2	238,637.6	(371,703.9)	-65.8%	45,517.4	23.6%
Богино хугацаат өр	538,922.5	227,346.0	465,583.2	(311,576.50)	-57.8%	238,237.20	104.8%
Урт хугацаат өр	565,211.3	565,211.3	565,211.3	-	0.0%	-	0.0%
Өглөгийн дүн	1,104,133.8	792,557.3	1,030,794.5	(311,576.5)	-28.2%	238,237.2	30.1%

Дээрх хүснэгтээс харахад 2016 оны нийт авлага 65.8, нийт өглөг 28.2 хувиар суурь оноос буурсан бол 2017 оныг өмнөх онтой харьцуулан үзэхэд нийт авлага 23.6, нийт өглөг 30.1 хувиар тус тус нэмэгджээ.

2017 оны авлага өглөгийн тооцоо нийлсэн акт болон үлдэгдлийг түүвэрлэн шалгахад урт хугацаат зээлийн 565211.3 мянган төгрөгийг 2009 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 3/1538 тоот албан бичгийн дагуу Арабын эдийн засгийн Кувейтийн сангийн хөнгөлөлтэй зээлийн хөрөнгөөр санхүүжигдсэн 16 нэр төрлийн машин механизмыг үндсэн хөрөнгөдөө бүртгэж санхүүгийн тайланд урт хугацаат зээлээр бүртгэгдсэн боловч зээлийн гэрээ байгуулаагүй, хүүний хэмжээ, ямар эх үүсвэрээс төлөгдөх нь тодорхойгүй, мөн “Орхон АЗЗА “ ТӨХК-тай дараа тооцоогоор гэж 3000.0 мянган төгрөг бэлэн гаргасан, ажлаас халагдсан ажилтнаас 1068.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 5 иргэний 6419.8 мянган төгрөг буюу сэлбэг материалын үнэ шилжүүлээд одоог хүртэл сэлбэг материалыг хүлээж аваагүй зэрэг зөрчил илэрсэнд авлага барагдуулахаар нийт 7488.1 мянган төгрөгийн албан шаардлага бичлээ.

Тус компани нь харилцагч байгуулагууд болон иргэдтэй жилийн эцэст тооцоо нийлж авлага, өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, материалын үнийг шилжүүлээд материалаа хүлээн аваагүй, он дамнасан, тодорхойгүй мөнгө гаргаж авлагаар тусгаж авлагыг барагдуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, авлага, өглөгийг нэмэгдүүлж ажиллажээ.

2017 онд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр аймгийн Нэгдсэн эмнэлгийн зүүн урд талаас НИК ШТС-ийн зүүн тал хүртлэх 0.482 км хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын гүйцэтгэх тендер оролцохдоо 2 ба түүнээс дээш тооны хуулийн этгээдтэй хамтран туслан гүйцэтгэгч эсвэл, түншлэлийн гэрээгүйгээр тендерийн баримт бичгийг бүрдүүлж тендер оролцон тухайн тендерийг 314787.3 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр 2017 он 03 дугаар сарын 28-ны өдөр Булган аймгийн Засаг даргатай гэрээ байгуулжээ.

Уг тендерийн ажлыг “Нигүүлсэн зам” ХХК-иар хатуу хучилттай замын барилгын ажлыг 260000.0, “Сувдан элс” ХХК-иар замын ажлын явган хүний замын хашлага, хучилт, суурийн ажлыг 40812.4 мянган төгрөгөөр тус тус гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТ-ийн 41.2 дахь “Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн ажлын гүйцэтгэлийг шилжүүлсэн санхүүжилт, тооцоо нийлсэн акттай тулгахад “Нигүүлсэн зам” ХХК-д 3532.2 мянган төгрөгийг илүү шилжүүлсэнг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй зөрчилд 3532.2, “Нигүүлсэн зам” ХХК-иар гүйцэтгүүлсэн ажлын худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татвар 23713.8 мянган төгрөгийг бүртгэл тайланд авлагаар тусгаагүй нь Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хуулийн 14.1.1 дэх заалтыг зөрчсөн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Цаг хугацаа өнгөрөх тусам авалагын эргэц удааширч найдваргүй болох эрсдэлтэй учраас харилцагч байгууллага болон иргэд хувь хүмүүстэй хагас бүтэн жилээр авлага, өглөгийн үлдэгдэлийг баталгаажуулан, санхүүгийн тайлан бүртгэлд үнэн зөв тусгаж, авлага, өглөгийг нэмэгдүүлэхгүй ажиллах шаардлагатай байна.

2.5. Хөрөнгө худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 48.1 дэх заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, худалдах худалан авах гэрээ байгуулаагүй, анхан шатны баримтын бүрдэлтийг бүрдүүлж ажиллаагүй, хөрөнгө бэлтгэхтэй холбоотой гарсан зардал болон зардлыг ангилан бүртгэхдээ холбогдох НББОУС-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тус ТӨХК төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 2016 онд 52300.0, 2017 онд нь 130000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлуулжээ.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

Бараа бүтээгдэхүүний нэр	2016 он		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	Нийт өртөг	Нийт өртөг	
Үйлчилгээний машин /мосттой, давхар кабинтай/	16,000.00	16,000.00	-
Цахилгаан үүсгүүр	4,500.00	4,500.00	-
Гражийн засвар	10,000.00	10,000.00	-
Гүний худаг	7,000.00	6,000.00	1,000.00

/мян.төг/

Гражийн засвар	5,000.00	5,000.00	-
Үйлчилгээний машин	9,800.00	11,000.00	(1,200.00)
лед гэрэл	-	13,000.00	(13,000.00)
3 үйлдэлт принтер	-	798.00	(798.00)
Нотебүүк	-	890.00	(890.00)
Нийт дүн	52,300.00	67,188.00	
	2017 он		
Автогрейдр	80,000.00	79,850.00	150.00
Индүү	50,000.00	60,000.00	(10,000.00)
Буйдан хар	-	2,135.00	(2,135.00)
Захирал ширээ хар	-	1,600.00	(1,600.00)
Телевизор LG42 smart	-	3,271.80	(3,271.80)
нотебүүк	-	1,300.00	(1,300.00)
Нийт дүн	130,000.00	148,156.80	

Хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаатай холбоотой гүйцэтгэлийг шалгахад ТУЗ-ийн шийдвэргүй буюу хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 14688.0 мянган төгрөгийн хөрөнгийг 2016 онд, 8306.8 мянган төгрөгийн хөрөнгийг 2017 онд, төлөвлөгөөнд тусгагдсан боловч төсөвт өртөгөөс хэтрүүлэн 1200.0 мянган төгрөгийг 2016 онд, 10000.0 мянган төгрөгийн 2017 онд тус тус худалдан авалтуудыг хийсэн нь ТБОНӨХБҮХАТХ-ийн 48.1, “Булган АЗЗА” ТӨХК-ний дүрмийн 7.3.15, 8.9.3 , 8.9.9 дэхь заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Мөн 2016 оны худалдан авах ажиллагаатай холбоотой баримт материал байхгүй, архивын нэгж болгон хадгалаагүй /олдохгүй байгаа гэсэн тайлбар амаар өгсөн/, 2017 оны худалдан авалдан авах ажиллагаатай холбоотой тендерийн материалын бүрдэл хангалтгүй, архивын нэгж үүсэх стандартыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна. Тухайлбал:

- 2016 онд Үйлчилгээний машин /мосттой, давхар кабинтай/ худалдан авсан тендэртэй холбоотой баримт материал байхгүй, үйлчилгээнд ашиглах 11000.0 мянган төгрөгийн кровон маркын машин худалдан авах, 13500.0 лед гэрлэн самбар хийлгэхэд тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн, Дашинчилэн сумын гражийн засвар, зоон давааны гражийн засвар хийсэн гүйцэтгэл тодорхойгүй,
- 2017 онд замын индүүг худалдан авахдаа тендер зарласан гэх боловч тендерын баримт бичгээс өөр баримт материал байхгүй, 2017 оны 12 сарын 01-ний өдөр иргэн Ц.Цэрэнчулуунтай 60000.0 мянган төгрөгийн гэрээг байгуулан төсөвт өртөгийг 10000.0 төгрөгөөр хэтрүүлэн гэрээ байгуулсан зэрэг нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.2, 21.1, 47.1, 47.4, 49.1 заалтуудтай нийцэхгүй байна.

- шатахууны 7-12 сарын баримт харгалзан 597, 453, 579, 590, 522, 303 хуудастай байгаа нь хадгаламжийн нэгжийг бүрэн дугаарлаагүй нь Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 3.3.2-т заасны дагуу хадгаламжийн нэгж 250 хүртэл хуудастай байх, 3.4.8-д “...бүх хуудсыг дугаарласан байх...” гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зэрэг зөрчил илэрлээ.

“Булган АЗЗА” ТӨХК нь байнгын системийг ашигладаг, өртгийг дундаж өртгийн аргаар тооцдог зам засвар, арчлалтын үйлдвэрлэл эрхэлдэг бөгөөд НББОУС-2-т заасны дагуу үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахтай холбоотой бараа материал бэлтгэхэд гарч буй бэлтгэл ажиллагааны зардал */Бараа материалыг худалдан авах, худалдах явцад тээвэрлэх бэлтгэхтэй холбогдсон зардал/* -ыг худалдан авсан тухайн бараа материалын өртөгт шингээж тооцдоггүй, шууд зардлаар бүртгэн үйлдвэрлэлийн нийт өртөгт шингээгдсэн байна. Бэлтгэл ажиллагааны зардлыг хэрхэн бүртгэж тайлагнах талаар компаний бодлогын баримт бичигт тодорхой тусгаагүй нь НББОУС-2-той бүрэн нийцэх үндэслэл болж чадахгүй байгаа тул байгууллагын онцлогт тохирсон НББОУС, УСНББС-д нийцсэн бодлогын баримт бичигтэй болох шаардлагатай байна.

2016 онд зардлыг гарч буй тухайн үйлдвэрлэл, үйлчилгээнд бүрэн бүртгэж ажиллаагүй байна. Өөрөөр хэлбэл Бусад гэсэн нэр бүхий дансанд ҮНЗ-аар 185442.7 болон ДҮ зардлаар 107787.0 нийт 293229.7 мянган төгрөгийг бүртгэн Улсын чанартай зам, засварын өртөгт шингээсэн байна. Тухайн ажлын гүйцэтгэл бүртгэлээрх ажлын зардлын дүн зөрж буйг тодруулахад бусад зардал хэсэгт тусгасан талаар тайлбар өгсөн. */Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харах/*

2017 оны шатахуун, сэлбэг, бараа материалын үлдэгдлийг түүвэрлэн үзэхэд талоны орлого, зарлагын үлдэгдлийг 38.5 мянган төгрөгөөр илүү, нэхэмжлэх баримтгүй 22000.0 мянган төгрөгийн шатахууны үнэ шилжүүлсэн, бараа тээвэрлэлтийн гэрээ байгуулж ажиллаагүй ажлын хөлс хэдийг өгөх нь тодорхойгүй зардалд 2868.6 мянган төгрөгийг, байгууллагын даргын цохолтгүй 2757.5 мянган төгрөгийн шатахуун тус тус зарцуулсан зөрчлүүд илэрч тайлангаар шатахууны илүү тусгасан 38.5 мянган төгрөгийн зөрчил, 5626.1 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу зөрчлүүдийг аудитын явцад барагдуулж ажиллаа.

Тус компани нь ихэвчлэн материалын урьдчилгаа, сэлбэгийн зардалд харилцахаас 101207.7, бэлнээр 161123.7 мянган төгрөгийг тус тус зарцуулж үүнээс 39400.0 мянган төгрөгийн сэлбэг материал худалдан авахдаа худалдах, худалдан авах гэрээ байгуулаагүй, материалыг хүлээн аваагүй, шаардагдаж байгаа хөрөнгө материалын төсвийг төлөвлөж зарцуулаагүй, тушаал шийдвэр гаргалгүй шууд худалдан авалт хийж иргэнд бараа материалын үнийг шилжүүлсэн, хяналт сул, бэлэн мөнгөний тайлангаас 18334.8 мянган төгрөгийн сэлбэг материалын үнийг шилжүүлэхдээ нэхэмжлэх, зарлагын баримтгүй шилжүүлсэн, шатахууны тайланг бараа материалын тодруулга тайланд тайлагнадаггүй шууд зардлаар тайлагнасан

зөрчлүүд илэрч хувь хүнд шилжүүлсэн 39400.0 мянган төгрөгнөөс 3940.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй зөрчилд төлбөрийн акт, бараа материал хүлээн аваагүй 35460.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага тус тус бичлээ.

Дээрхи зөрчлүүд нь НББ-ийн тухай хуулийн 13.7.”Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 7.1.”Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна”, ХХОАТ-ын тухай хуулийн 23.1“энэ хуулийн 17-19 дүгээр зүйл 20.1.2-201.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэсэн заалтууд болон худалдан авах журмыг баримтлан ажиллаагүй байна.

Хөрөнгийн тооллогыг комисс томилон хагас жилээр болон жилийн эцэст холбогдох хуулийн дагуу явуулжээ.

2016 онд хөрөнгийг бүртгэж тайлагнахдаа хэрэглэгдэх байдал, ашиглалтын хугацааг харгалзаж үзээгүйгээс 18 нэр төрлийн 13997.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалаар бүртгэж тайлагнасанг санхүүгийн тайлангийн аудитаар залруулга хийлгэсэн байна. Залруулах бичилт хийхдээ оны эцсийн үлдэгдлээр тусгагдсан үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцолгүйгээр 2016 оны 12 дугаар сарын сүүлээр орлого авч бүртгэсэн нь НББОУС-16 болон Сангийн сайдын 388 дугаар журмын 4.36-д заасан заалттай нийцэхгүй байна.

Дээр илэрсэн зөрчлүүдээс дүгнэхэд байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул, ТУЗ-ийн хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бодитой үнэн зөв төлөвлөх, үндсэн хөрөнгө болон бараа материал худалдан авахдаа худалдах,худалдан авах гэрээг байгуулж шаардагдаж байгаа хөрөнгө, материалын төсвийн зардлыг төлөвлөн батлуулж ажиллах, бараа материал нийлүүлэх хугацаанаас нь хамааран төлбөр тооцоог хийж материал сэлбэг авах авлагагүй ажиллах, харилцах дансаар анхан шатны баримтын бүрдэлтэй ажил гүйлгээг хийж хэвших, ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаагүйгээс ашиг сонирхолын зөрчил үүсэх, бэлэн мөнгө зарцуулах журмыг мөрдөж ажиллаагүйгээс бэлэн мөнгийг ашиглан шамшигдуулалт үүсэж болзошгүй эрсдэлтэй байгаад онцгой анхаарч ажиллах, хөрөнгө оруулалтын худалдан авах ажлыг сайжруулах шаардлагатай байна.

Булган аймаг дахь
Төрийн Аудитын газар

Дотоод хяналт болон шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилт, биелэлт

Бүлэг 3

Байгууллагын дотоод хяналт сул, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.1. Байгууллага үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын төлөвлөгөөг батлуулсан боловч төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.

Тус байууллага нь 2016, 2017 онд дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг гүйцэтгэх захиралаар батлуулж, гүйцэтгэлийг гаргасан боловч “Булган АЗЗА” ТӨХК-ий дүрмийн 10.5-д компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал: Байгууллагын дотоод хяналтын албыг байгуулаагүй, ТУЗ 2017 оны байдлаар 5 удаа хуралдаж хурлаар байгууллагын өр авлагыг зорилтот түвшинд тогтоосон хэмжээнд барьж өр авлагыг бууруулж ажиллах, өмнөх аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилган өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, худалдан авалтыг батлагдсан төлөвлөгөө, холбогдох хууль журмын дагуу явуулах, ажлын төлөвлөгөөний дагуу замын тэмдэг тэмдэглэгээ, мэдээ, мэдээллийг тухай бүр нь шинэчлэн аюулгүй байдлыг ханган ажиллах, мөн хорооны гишүүдэд компанийн дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үүрэг өгч нийт 17 зөвлөмж хүргүүлэн ажилласан боловч аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс дүгнэж үзэхэд өгсөн зөвлөмж үүргээ биелүүлээгүй алдаа зөрчил давтагдаж төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үүргээ бүрэн биелүүлж ажиллаагүй, санхүүд тавих дотоод хяналт суларсан байна.

Цаашид ТУЗ-ийн гишүүд байгууллагын үйл ажиллагаа болон санхүүд тавих дотоод хяналтыг сайжруулан өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.2. Шилэн дансны тухай хуулийн 4.1.3 дахь “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.8 дахь “... төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4.2.2 болон 4.2.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Булган АЗЗА” ТӨХК нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг 2016 оноос байршуулж эхэлсэн бөгөөд Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2.1-д заасны дагуу шилэн дансны үндсэн дөрвөн цэсний өөрт хамаарал бүхий 2 цэсэнд 7 төрлийн мэдээлэл байршуулахаас 2016 оны 07 дугаар сарын мэдээллээс бусад мэдээллийг хугацаа хоцроож, Худалдан авах ажиллагааны тайлан жилээр мэдээлэх хэсэгт “Евробитум” ХХК-тай 21.0 сая төгрөгийн өртөгтэй 2016 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр байгуулж 12 дугаар сарын 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгох гэрээг хийсэн тухай мэдээлж бусад бүх мэдээллийг гүйлгээ хийгдээгүй, хамааралгүй гэж мэдээлсэн байна. Гэвч уг ТӨХК нь улсын болон орон нутгийн зам засвар, үйлдвэрлэлийн хүрээнд 2016 онд харилцан адилгүй өртөг, үнийн дүнтэй 58 удаагийн нийт 1,996,146.9 мянган төгрөгийн гэрээнүүдийг хийсэн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс харна уу/ Мөн тайлант онд 71,370.0 мянган төгрөгийн зээлийг хувь хүнээс авч тайлант онд бүрэн барагдуулжээ. Дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээс харна уу.

Цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг хамааралгүй, гүйлгээ хийгдээгүй гэж мэдээлсэн байгаа нь шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4.2.3 дахь “зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй

адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдөр нь зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн баримтад заасан маягтын дагуу PDF форматаар”, 4.2.2 дахь “хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэ журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” мэдээлэх гэж заасныг тус тус бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил илэрлээ. Иймд тухайн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаар нийт 2296385.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 558.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5626.1 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад барагдуулж, 40955.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 2249246.5 мянган төгрөгийн албан шаардлага тус тус бичиж ажиллалаа.

ДҮГНЭЛТ:

“Булган АЗЗА” ТӨХК-ий 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаа, хууль, журмын хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- *Үйл ажиллагааны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг төлөвлөхдөө тооцоо судалгаанд үндэслэдэггүй, мөн орон нутгийн зам засварын арчлалт, бусад үйл ажиллагааны борлуулалтын орлогыг бүрэн тооцоогүй, гүйцэтгэсэн ажлын дутуу санхүүжилтийг тайлант онд бүртгэхгүй дараа онд шилжүүлэн орлогоор хүлээн зөвшөөрч тухайн жилийн эдийн засаг үндсэн үзүүлэлт, зорилтод түвшингийн гүйцэтгэлийг гаргаж дүгнүүлсэн байгаа зэрэг нь ТӨХК-ний эдийн засгийн үзүүлэлт бодиттой дүгнэгдэхгүй байх эрсдэл байгаа,*
- *Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу зарцуулаагүй,*
- *Харилцагч байгууллага, хувь хүнтэй тооцоо нийлж баталгаажуулдаггүй, санхүүгийн менежментийн тооцоолол хийгдээгүйгээс тайланд оны авлага, өглөг төлөвлөгөөнөөс нэмэгдэн эргэц удааширсан,*
- *Ямар нэр төрлийн, хэдэн тооны материал худалдан авах нь тодорхойгүйгээр бэлэн мөнгөөр урьдчилгаа олгодог, материалыг орлогод авах хугацаа харьцангуй хойно хийгддэг,*
- *Томилолтын хугацаанд хоолны мөнгө давхардуулж олгодог, өглөг дутуу бүртгэж тайлагнасан, анхан шатны баримтын бүрдэл дутуу болон бүрдэлгүй ажил гүйлгээ хийсэн,*
- *Зардлыг тухайн гарсан ажлын өртөгт үнэн зөв бүртгэж тайлагнадаггүй, материал бэлтгэхтэй холбоотой гарсан зардлын материалын өртөгт шингээж тооцдоггүй,*

- *Материал зарцуулахдаа даргын цохолтгүй, хүлээж авсан болон хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг дутуу, зарлагын гүйлгээг цаг хугацаанд нь хийгээгүйгээс ажил хүлээлцсэн материалын дүн хүлээж авсан няравын тайлангаарх материалын дүн зөрсөн,*
- *Хувь хүнтэй гэрээ хийн ажил үйлчилгээ худалдан авахдаа ХХОАТ-ыг суутгадаггүй, суутгасан ч холбогдох байгууллагад төлөхөөр өглөгөөр тусгаагүй,*
- *Жолоочийн замын хуудсыг тухай бүр хөтөлдөггүй, авсан шатахуунд тааруулж бичилт хийдэг,*
- *Санхүүгийн баримт материалыг хадгаламжийн нэгжээр үүсгэхдээ холбогдох архивын тухай хууль, стандартыг бүрэн мөрдөөгүй,*
- *ТУЗ-өөс өгсөн зөвлөмж үүргийг дутуу биелүүлж алдаа зөрчил давтагдаж төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд үүргээ бүрэн биелүүлж ажиллаагүй санхүүд тавих дотоод хяналт суларсан,*
- *Шилэн дансны цахим хуудсанд хамаарал бүхий мэдээллийг бүрэн байршуулдаггүй, хууль, журмыг бүрэн хэрэгжүүлээгүй зэргээс үзэхэд дотоод хяналт болон ТУЗ-ийн хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бодитой үнэн зөв төлөвлөх, үндсэн хөрөнгө болон бараа материал худалдан авахдаа худалдах худалдан авах гэрээг байгуулж шаардагдаж байгаа хөрөнгө, материалын төсвийн зардлыг төлөвлөн батлуулж ажиллах, бараа материал нийлүүлэх хугацаанаас нь хамааран төлбөр тооцоог хийж материал сэлбэг авах авлагагүй ажиллах, харилцах дансаар анхан шатны баримтын бүрдэлтэй ажил гүйлгээг хийж хэвших, ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.*

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

1. “Булган АЗЗА” ТӨХК-ий төлөөлөн удирдах зөвлөлд:

- *Төлөөлөн удирдах зөвлөлөөс тавих дотоод хяналт, хариуцлагыг сайжруулах, хууль, тогтоомж зөрчсөн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох.*

2. “Булган АЗЗА” ТӨХК-ий захиралд:

- *Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа хүлээгдэж буй аливаа эрсдэлийг тооцон батлуулж, батлуулсан төлөвлөгөөний дагуу зарцуулалт хийдэг байх.*
- *Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулсан НББОУС, УСНББОУС-д нийцсэн бодлогын баримт бичигтэй болох, ажил тус бүрээрх гарсан зардлыг өртөгт үнэн зөв бүртгэж тайлагнах.*

- Хөрөнгө бэлтгэх болон зарцуулахдаа НББийн тухай хуулийн 4.1.2, 4.1.6, 5.1, 7.1, 7.5-7.7, 9.1-9.3, 14.1, ХХОАТ-ын тухай хуулийн 26.1, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.4, 19.1, 48.5, 49, шилэн дансны тухай хуулийн 4.1.3, 6.4.8 болон Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 4.2.2-4.2.3 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж, санхүүгийн баримтыг хадгаламжийн нэгжээр үүсгэхдээ Архивийн тухай хууль стандартыг мөрдөж ажиллах.
- Аливаа зээлийг холбогдох гэрээний үндсэн дээр хийж, авлаг, өглөгийг харилцагч хувь хүн болон байгууллагатай хагас жилээр болон жилийн эцэст тооцоо нийлж хэвших, авлага, өглөгийн насжилтанд анхаарч эргэцийн багасгах тал дээр анхаарч шат, шатны холбогдох дотоод хяналтыг сайжруулах,
- Бэлнээр ажил гүйлгээ хийхийг багасгаж шаардагдаж байгаа хөрөнгө материалаа тухай бүр төсөвлөн батлуулж харилцагч дансаар нэхэмжлэх баримтаар ажил гүйлгээг шилжүүлж хэвших.

Мэдэгдэл:

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гарсан үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар сарын 01-ний дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:		ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ АУДИТОР	Г.НАМЧИНСҮРЭН	БУЛГАН “АЗЗА” ТӨХК-ИЙ ЗАХИРАЛ
АУДИТОР	А.СУВДАА	Б.БАТСАЙХАН
АУДИТОР	П.МӨНХТУЯА	ЕРӨНХИЙ НЯГЛТАН БОДОГЧ
		Д.АМГАЛАН
		ТООЦООНЫ НЯГТЛАН БОДОГЧ
		Д.БУРМАА

